



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэрлэн сумын 16 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДОА-2022/147/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот  
2022 он

*Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул*

*Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn*

*Аудитын менежер: И.Сэмжидмаа*

*Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn*

*Ахлах аудитор: Д.Нармандах*

*Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn*

*Аудитор: А.Даваасүрэн*

*Утас: 70003775, 88883776*

*Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com*

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.6.1 Төсвийн төлөвлөлт .....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал .....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт .....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	<b>Error! Bookmark not defined.</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

## 1. Аудитын санал дүгнэлт



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.02.25 № 235

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН  
16 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Д.ГАНТУЯА ТАНАА

#### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

##### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 16 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын 16 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

##### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

##### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

##### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

011020148

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>4,122,946.00</u></b>	<b><u>5,289,827.00</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	4,122,946.00	5,289,827.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,778,446.00	4,154,101.00
35110	Тусгай зориулалттай материал	1,531,446.00	3,907,101.00
35130	Эм боох материал	247,000.00	247,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	2,344,500.00	1,135,726.00
35410	Бичиг хэргийн материал	466,900.00	550,800.00
35420	Аж ахуйн материал	80,000.00	312,876.00
35450	Барилгын засварын материал	17,000.00	24,450.00
35460	Хүнсний материал	1,780,600.00	-
35470	Бусад хангамжийн материал	-	247,600.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>27,863,842.84</u></b>	<b><u>23,090,426.18</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	27,863,842.84	23,090,426.18
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	26,708,842.84	22,166,426.18
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	4,921,135.00	5,814,135.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(189,618.08)	(1,188,728.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,531,530.00	1,531,530.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(204,204.08)	(510,510.20)
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,650,000.00	20,650,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(4,130,000.04)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	1,155,000.00	924,000.00
39301	Программ хангамж	1,155,000.00	1,155,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(231,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>31,986,788.84</u></b>	<b><u>28,380,253.18</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>31,986,788.84</u></b>	<b><u>28,380,253.18</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	31,986,788.84	28,380,253.18
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	31,986,788.84	28,380,253.18
51210	Өмнөх үеийн үр дүн	31,986,788.84	31,986,788.84
51220	Тайлант үеийн үр дүн	-	(3,606,535.66)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>31,986,788.84</u></b>	<b><u>28,380,253.18</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>250,382,465.00</b>	<b>287,893,398.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>1,475,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	1,475,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,475,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	1,475,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>27,102,665.00</b>	<b>34,924,698.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	223,279,800.00	251,493,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	33,924,698.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	33,924,698.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	1,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	1,000,000.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	27,102,665.00	-
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	27,102,665.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>218,395,676.16</b>	<b>291,499,933.66</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>218,395,676.16</b>	<b>291,499,933.66</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	210,723,019.59	230,388,944.73
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	172,095,515.43	182,282,589.76
210101	Үндсэн цалин	130,966,818.46	146,711,099.76
210102	Нэмэгдэл	27,988,813.27	18,345,163.00
210104	Урамшуулал	13,139,883.70	17,226,327.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	21,537,700.00	24,041,842.31
210201	Тэтгэврийн даатгал	14,645,500.00	16,728,062.39
210202	Тэтгэмжийн даатгал	1,723,000.00	1,897,771.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,378,400.00	1,474,735.97
210204	Ажилгүйдлийн даатгал	344,600.00	358,215.35
210205	Эрүүл мэндийн даатгал	3,446,200.00	3,583,057.38
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,261,280.00	2,077,479.00
210401	Бичиг хэрэг	154,500.00	413,295.00
210402	Тээвэр, шатахуун	487,500.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	120,000.00	130,000.00
210404	Ном, хэвлэл	54,900.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	244,550.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	444,380.00	789,634.00
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	15,045,102.00	13,986,862.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	75,500.00	1,514,590.00
210502	Хоол, хүнс	14,969,602.00	12,472,272.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	975,550.00
210604	Урсгал засвар	-	975,550.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	148,400.00	522,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	148,400.00	522,400.00

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	635,022.16	6,502,221.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	250,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	241,200.00	585,805.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	393,822.16	5,666,416.66
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	7,672,656.57	61,110,988.93
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	113,000.00	34,191,664.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	33,878,664.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	113,000.00	313,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	7,559,656.57	26,919,324.93
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>31,986,788.84</u></b>	<b><u>(3,606,535.66)</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>31,986,788.84</u></b>	<b><u>(3,606,535.66)</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	31,986,788.84	31,986,788.84
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	<b>31,986,788.84</b>	31,986,788.84
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	<b>31,986,788.84</b>	31,986,788.84
Тайлант үеийн үр дүн	-	-	(3,606,535.66)	(3,606,535.66)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	<b>28,380,253.18</b>	28,380,253.18

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>223,279,800.00</u></b>	<b><u>286,418,398.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>223,279,800.00</u></b>	<b><u>286,418,398.00</u></b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	223,279,800.00	251,493,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	33,924,698.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	33,924,698.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	1,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	1,000,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>223,279,800.00</u></b>	<b><u>286,418,398.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>223,279,800.00</u></b>	<b><u>286,418,398.00</u></b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b><u>215,607,143.43</u></b>	<b><u>225,307,409.07</u></b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	172,095,515.43	182,282,589.76
210101	Үндсэн цалин	130,966,818.46	146,711,099.76

210102	Нэмэгдэл	27,988,813.27	18,345,163.00
210104	Урамшуулал	13,139,883.70	17,226,327.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>21,537,700.00</b>	<b>24,041,842.31</b>
210201	Тэтгэврийн даатгал	14,645,500.00	16,728,062.39
210202	Тэтгэмжийн даатгал	1,723,000.00	1,897,771.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,378,400.00	1,474,735.97
210204	Ажилгүйдлийн даатгал	344,600.00	358,215.35
210205	Эрүүл мэндийн даатгал	3,446,200.00	3,583,057.38
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,901,726.00</b>	<b>4,590,400.00</b>
210401	Бичиг хэрэг	232,700.00	444,700.00
210402	Тээвэр, шатахуун	487,500.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	158,000.00	130,000.00
210404	Ном, хэвлэл	220,046.00	150,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	256,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	703,480.00	3,108,500.00
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	<b>18,040,502.00</b>	<b>11,941,877.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	236,100.00	184,034.00
210502	Хоол, хүнс	16,750,202.00	10,691,672.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,054,200.00	1,066,171.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	<b>1,000,000.00</b>
210604	Урсгал засвар	-	1,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,303,400.00</b>	<b>522,400.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,303,400.00	522,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>728,300.00</b>	<b>928,300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	250,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	728,300.00	678,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,672,656.57</b>	<b>61,110,988.93</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>113,000.00</b>	<b>34,191,664.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	33,878,664.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	113,000.00	313,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,559,656.57</b>	<b>26,919,324.93</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	252,493,700.00	225,574,375.07
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	252,493,700.00	225,574,375.07
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	252,180,700.00	225,261,375.07
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	205,449,800.00	182,282,589.76
210101	Үндсэн цалин	160,803,500.00	146,711,099.76
210102	Нэмэгдэл	19,969,400.00	18,345,163.00
210104	Урамшуулал	24,676,900.00	17,226,327.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>27,318,800.00</b>	<b>24,041,842.31</b>
210201	Тэтгэврийн даатгал	19,100,500.00	16,728,062.39
210202	Тэтгэмжийн даатгал	2,054,600.00	1,897,771.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,643,900.00	1,474,735.97
210204	Ажилгүйдлийн даатгал	410,900.00	358,215.35
210205	Эрүүл мэндийн даатгал	4,108,900.00	3,583,057.38

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,590,400.00	4,590,400.00
210401	Бичиг хэрэг	444,700.00	444,700.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	130,000.00	130,000.00
210404	Ном, хэвлэл	150,600.00	150,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	463,000.00	256,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,902,100.00	3,108,500.00
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	12,371,000.00	11,895,843.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,000.00	138,000.00
210502	Хоол, хүнс	11,166,800.00	10,691,672.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,054,200.00	1,066,171.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	522,400.00	522,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	522,400.00	522,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	928,300.00	928,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	250,000.00	250,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	678,300.00	678,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	313,000.00	313,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	313,000.00	313,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	313,000.00	313,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	252,493,700.00	225,574,375.07
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	251,493,700.00	224,574,375.07
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	251,493,700.00	224,574,375.07
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,000,000.00	1,000,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	1,000,000.00	1,000,000.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	18	18
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	16	16
620003	Үйлчлэх ажилтан	1	1

## 2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>33,924,698.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>33,924,698.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	46,034.00
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	46,034.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	46,034.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	33,878,664.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	33,878,664.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,878,664.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	33,878,664.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	33,878,664.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,878,664.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэрлэн сумын 16 дугаар Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан консалтинг аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал Э.Нандинчимэг, аудитор А.Даваасүрэн нар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэрлэн сумын 16 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 1/02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь Хүүхдийн хөгжлийг дэмжих, тэдэнд тулгарч буй бэрхшээлийг арилгах, суралцахад нь хамтын ажиллагаа, оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй боловч 2018 онд Дорнод аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан “Дорнод аймгийн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллага нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгжгүй бөгөөд хяналтыг байгууллагын удирдлага хэрэгжүүлэн ажилладаг байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэрлэн сумын 16 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 төсвийн гүйцэтгэлийн тайлангаас сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны батлагдсан төсөвт зардлын дүн 223,280.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 4,465.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,349.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Бараа материалын дансны үлдэгдэл 5,289.8 мянган төгрөг болж 1,166.8 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын худалдан авалттай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 29,150.6 мянган төгрөг болж 893.0 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн данс нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар 893.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжөөр нэмэгдсэн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 37,511.0 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого болон орон нутгаас хуваарилсан мөнгөн хөрөнгөтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 73,104.2 мянган төгрөгөөр өссөн нь бараа, ажил үйлчилгээний зардал өссөнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх 252,493.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 252,493.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 252,493.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 251,493.7 мянган төгрөгийг улсын төсвөөс 1,000.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,000.0 мянган төгрөг, улсын төсвөөс 251,493.7 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт 252,493.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 225,574.4 мянган төгрөг буюу 89.3 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд 26,919.3 мянган төгрөг буюу 10.6 хувийг татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хэрлэн сумын дээд шатны төсвийн захирагчаас 33,924.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 46.0 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 33,878.6 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хэрлэн сумын 16 дугаар Цэцэрлэг нь 2021 онд Шилэн дансны мэдээллийн тулгалтаар цахим хуудсанд хуулийн хугацаанд бүх мэдээллийг байршуулсан байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17 -ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасны дагуу бүх шатны байгууллагын төсөв захирагч буюу эрхлэгч тушаал шийдвэр гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаагүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,904.9 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,464.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,464.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн.

### 4.1 Албан шаардлага

1. Дээд шатны байгууллагаас гаргасан шийдвэрээр тэвчиж болох тэтгэвэр тогтоолгосны дараа орон тоог царцаалгүй 964.8 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 43 дугаар тогтоолын 1.2-т “Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх” гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Шатахууны зардалд төлсөн 500.0 мянган төгрөгийн анхан шатны баримт жолоочийн тооцооны хуудасны иж бүрдэл дутуу байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх ба үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дээрх биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын эр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хэрлэн сумын 16 дугаар цэцэрлэг	2	1.4	-	-	-	-	2	1.4	-	-